

Ерөнхий чуулганд бэлтгэх

Есүс Христ нифайчууд дээр айлчлах үедээ Өөрийнх нь захиасыг сонсож, ойлгож болохын тулд оюун санаагаа бэлтгэхэд тэднийг урьсан (3 Нифай 17:3-ыг үзнэ үү). Та мөн ийн үйлдвэл Ерөнхий чуулганы туршлага тань ямар байхыг төсөөл.

1. Дараах эх сурвалжийг судлаад, Ерөнхий чуулганаар Их Эзэний захиасыг хүлээн авахын тулд өөрийгөө бэлтгэх арга замуудыг олж мэд. Та онцгой санагдсан үг, хэллэгүүдийг тэмдэглэж болно.

Мозая 2:9; Сургаал ба Гэрээнүүд 88:63.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон ийн заасан.



Өнөөдөр мөн маргааш та бүхэн энэ индэр дээрээс үргэлжлүүлэн үнэнийг сонсох болно. Анхаарлыг тань татаж буй, оюунд тань ирж байгаа, зүрх сэтгэлд тань үлдэж буй бодлоо бичиж тэмдэглэж аваарай. Сонссон зүйл тань үнэн эсэхийг баталж өгөхийг Их Эзэнээс залбирч асуу. (Рассэлл М.Нэлсон, “Юу үнэн бэ?,” Лиахона, 2022 оны 11-р сар, 30)

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч Хэнри•Б.Айринг ийн заасан.



Энэ чуулган дээр Бурханы үйлчлэгчид та нарт хандан үг хэлнэ гэдгийг би мэднэ. Бурхан Өөрийн хүүхдүүдэд захиасаа өгүүлэхээр тэднийг дуудсан юм. Их Эзэн тэдний талаар: “Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, мөн би өөрийгөө зөвтгөх нь үгүй; мөн тэнгэр хийгээд газар үгүй болсон ч, миний үг алга болох нь үгүй, харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” [Сургаал ба Гэрээнүүд 1:38] гэж хэлжээ.

Та нар сурч мэдэх, наманчлах зорилготойгоор сонсож мөн явж, Түүний хүссэн бүхнийг биелүүлснээр Түүнд итгэх итгэлээ харуулдаг. Хэрэв та нар энэ чуулганы илтгэл, дуулал, залбирал болгоныг анхааралтай сонсож, Бурханд итгэх юм бол Түүний хэлэх гэсэн үгийг олж сонсоно. Дараа нь явж, Түүний хий гэснийг хийж чадвал та нарын Түүнд итгэх итгэл өсөж, Түүнийг та нарт итгэж найддаг талаар өөрсдөө олж мэдэн талархах болно. (Хэнри Б.Айринг, “Бурханд итгэ, тэгээд явж, ажилла,” 2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 75–76)

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч асан Дийтр•Ф.Угдорф ийн заажээ.



Ерөнхий чуулганд бэлтгэхдээ хариулт авах хэрэгтэй байгаа асуултуудынхаа талаар тунгаан бодоход би уриалж байна. Жишээ нь: Магадгүй та нар тулгарсан саад бэрхшээлтэйгээ холбоотой Их Эзэний заавар, зөвлөгөөг хүсэж болох юм.

Та нарын онцгой залбирлын хариулт тодорхой нэг хэлсэн үгээс эсвэл нэг өгүүлбэрээс ч шууд ирж болно. Бусад үед хариултууд ямар ч хамааралгүй мэт санагдах үг, өгүүлбэр эсвэл дуунаас ирж болно. Амьдрал дахь адислалууддаа талархсан талархлаар дүүрэн зүрх сэтгэл болон зөвлөгөө өгсөн үгсийг сонсож дагах чин сэтгэлийн хүсэл эрмэлзэл нь хувийн илчлэл авах арга замд бэлтгэх болно. (Дийтр•Ф.Угдорф, “Ерөнхий чуулган—Энгийн адислал гэж байдаггүй,” Тэргүүн зөвлөлийн захиас, 2010 оны 9-р сар)

2. Сурч мэдсэн зүйлээ ашиглан Ерөнхий чуулганаар Их Эзэний дуу хоолойг сонсоход бэлтгэх арга замуудыг жагсааж бич.
3. Ерөнхий чуулганаар Их Эзэний дуу хоолойг сонсоход бэлтгэх бусад арга замыг жагсааж бич.